

ШҮҮХИЙН ТОГТОЛЦООГ ӨӨРЧЛӨХ БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/ТӨВ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Шүүхийн тухай хууль, Шүүх байгуулах тухай шинэ хууль батлагдаж шүүхийн шинэ тогтолцоонд шилжсэнээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл байсан Төв аймгийн 27 сум шүүхийн харьяаллын хувьд 5 тасарсан байдаг.¹ Шүүхийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн шүүхийн тойргийн тогтолцооны давуу болон сул талыг Төв аймгийн жишээн дээр зардал-үр өгөөжийн харьцааг тооцоолох замаар харуулахыг зорилоо. Энэхүү кэйс судалгааг Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн бөгөөд судлаачдын боловсруулсан дүгнэлт, зөвлөмжийг энэхүү Бодлогын асуудлаар олны хүртээл болгож байна. (Судалгааны дэлгэрэнгүйг www.forum.mn хаягаар үзнэ үү).

2013 оны Шүүхийн тухай хууль нь шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх, ил тод, нээлттэй байх зарчмыг баталгаажуулах, шүүхийн дотоод хараат байдлыг бууруулах зохицуулалтыг багтааснаас гадна шүүхийн бие даасан байдлыг хангах эдийн засаг, улс төр, эрх зүй, аюулгүй байдал, зохион байгуулалтын чиглэлийн цогц баталгааг тусгаснаараа онцлог болсон. Уг хуулийн хүрээнд хяналтын шатныхаас бусад шүүхийг нутаг дэвсгэрийн

хэмжээ, хүн амын нягтаршил, суурьшлын харилцан уялдсан тогтолцоо, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулсан. Үүний үр дүнд Монгол Улсад давж заалдах шатны 21, анхан шатны 57 шүүх шинэчлэгдэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна.²

Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орж, шүүгч хэрэг маргааныг дагнан шийдвэрлэх болсноор шүүгчийн ажлын ачаалал буурч, тодорхой чиглэлээр мэргэших, хэргийн материалтай бүрэн танилцаж, оновчтой шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн. Үр дүнд нь шүүхийн үйлчилгээ хурдан, шуурхай болж, шийдвэрийн чанар сайжрах боломжтой болж байна. Үүний зэрэгцээ шинэчлэн байгуулагдсан шүүхүүд бие даасан, төвлөрсөн төсөвтэй болж түүнийгээ захиран зарцуулах эрх эдэлдэг болсон. Гэсэн хэдий ч Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн цагаасаа хойш багагүй маргаан дагуулж, шүүмжлэлд өртсөөр байна.

Төв аймгийн 10 сум өөр аймгийн шүүхэд харьяалагдах болсноор тус шүүхийн төсөв 50 гаруй хувиар багассан. Тухайн шүүхийн 2012-2015 оны төсвийн мэдээллийг

харахад бензин шатахуун, томилолтын зардал хоёр дахин багассанаас шүүх нүүдэллэн шүүх хуралдаан зохион байгуулах, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах /нээлттэй шүүх хуралдаан зохион байгуулах зэрэг/ ажлыг явуулах боломж хязгаарлагдсан, мөн шуудангийн зардал багассанаар давж заалдах шатны шүүхэд хэргийг хүргүүлэхдээ тодорхой хугацаанд багцлан илгээдэг болсон нь хэрэг маргааныг хурдан шуурхай шийдвэрлэхэд саад тотгор үүсгэж байна.

Шүүхийг тойргийн журмаар байгуулж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулсан нь цагдаа болон прокурорын байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл, чирэгдэл үүсгэсэн тухай шүүмжлэл их байна. Өөрийн засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг дээрх байгууллагын алба хаагчид бүтэц зохион байгуулалтын хувьд өөр нэгжтэй хамтарч ажиллахад цаг хугацаа алдах зэрэг асуудалтай тулгардаг аж. Эдгээр асуудал хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд болон иргэдэд нэгэн адил бухимдал, хүндрэл үүсгэж байна.

Эрх зүйн, түүн дотроо шүүхийн шинэчлэлийн талаар сонсоогүй,



Ж.БАРИАШИРСҮРЭН

Хууль зүйн магистр,
хуульч, ХЗҮХ-ийн
бодлогын судлаач



Ж.АРИУНЦЭЦЭГ

Олон улсын эдийн
засгийн харилцааны
бакалавр, ХЗҮХ-ийн
бодлогын судлаач



Б.ДОРЖПАГМА

Социологийн магистр,
Хуульчдын холбооны
судалгаа шинжилгээ
хариуцсан мэргэжилтэн

сонссон ч ойлгоогүй иргэн олон байгаа нь шүүхийн шинэтгэлийн талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалт хангалтгүй явагдаж байгааг баталж байна. Судалгаанаас харахад шүүх байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 32.4 хувь нь шүүхийн тогтолцооны өөрчлөлтийн талаар огт мэдээгүй гэж хариулсан. Шүүх байгууллагын талаарх мэдээллийг шүүхээр үйлчлүүлсэн иргэд хүртэл хангалттай хэмжээнд авч чадахгүй байгаа явдал нь иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил дутмаг байгаа, иргэд мэдээлэл “олж авах” хүсэл эрмэлзэл бага, шүүх, цагдаагийн зүгээс “иргэн өөрөө хуулиа олж мэдэх үүрэгтэй” гэх хандлага гаргадагтай холбоотой. Мөн сүүлийн үед техник, технологийн хөгжлийг даган төрийн байгууллагууд цахим хэлбэрээр мэдээлэл, сурталчилгаагаа явуулах болсон. Харин ийнхүү “цахимаар мэдээлэл тараах” явдал нь хүн амын талаас илүү хувь нь төвөөс алс оршин суудаг, интернетээс мэдээлэл авах нь бүү хэл телевиз үзэх боломж бүрэн бүрэлдээгүй өрхүүдтэй манай улсын хувьд учир дутагдалтай юм.

Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орсноор иргэдэд үүсэх ачаалал буюу зардлын үр нөлөөг Төв аймгийн жишээн дээр тооцож үзэхэд хууль санаачлагчийн “шүүхийг иргэдэд ойр сум, дүүрэгт харьяалуулан, тойргийн журмаар байгуулах нь шүүхийн үйлчилгээг иргэдэд аль болох ойртуулах” гэсэн санаатай нийцүүлэн шүүхийг орон зайн хувьд ойртуулсан мэт боловч бодит байдалд нийтийн тээвэр, зам харилцаанаас үүдэн хүндрэл үүсгэж, хэргийн онцлогоос хамааран зарим тохиолдолд зардал даруй хоёроос дөрөв дахин өссөн судалгааны дүн гарч байна. Шүүхийн байршил өөрчлөгдсөнөөр иргэн, айл өрхөд эдийн засгийн нэмэлт ачаалал бий болсон гэж дүгнэж болохоор байна.

ЗӨВЛӨМЖ

Дээрх нөхцөл байдалд үндэслэн судлаачдын зүгээс дараах хэдэн зөвлөмжийг Шүүхийн ерөнхий зөвлөлд санал болгож байна. Үүнд:

1. Иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх:

- Иргэдэд одоогийн тогтолцооны давуу талыг танилцуулж мэдээлэл хүргэх, мэдээ мэдээллийн төрөл хэлбэр, хүргэх арга замыг сайжруулах нь нэн тулгамдсан асуудал байна. Хүн ам олноороо суурьших хот суурин газарт цахим хуудас, телевизээр дамжуулан мэдээлэл хүргэж байгаа нь хүн бүрт мэдээлэл түгээх, тэгш хүргэх шаардлагыг хангахгүй байна. Интернет сүлжээ бүх газарт байдаггүй, өрхийн оршин суугаа газар, амьжиргааны түвшнээс хамааран компьютер, ухаалаг гар утас

айл бүрт байхгүй учир иргэдийнхээ амьдралын хэв маяг, нөхцөл байдалд тохируулан мэдээлэл хүргэх арга замыг боловсруулах шаардлагатай байна.

- Шүүхийн тойргийн хилийг тогтоохдоо тухайн орон нутгийн иргэдээс судалгаа авах, хэрэгцээ шаардлагыг бодит байдалд нийцүүлэн тодорхойлох зэрэг урьдчилсан тандалт, нөхцөл байдлыг үнэлсэн судалгаа хийж, үр дүнг нь олон нийтэд нээлттэй болгох;
- Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орсноор иргэдийн төлөх зардлыг тооцож иргэдийн шүүхэд хандах боломжийг хязгаарласан шийдвэрийг эргэж харах шаардлагатай.

2. Шүүхийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг арилгах:

- Засаг, захиргааны тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий удирдлагын “босоо” тогтолцоотой цагдаа, прокурор, бусад төрийн байгууллага өөр аймагт байрлах шүүхэд шийдвэрлэгдэж буй хэрэгт холбогдох нотлох баримт бүрдүүлэх, мэдүүлэг авах асуудлаар харилцахад хүндрэлтэй байгаа тул шүүхийн шинэтгэлийг хууль сахиулах байгууллагын шинэтгэлтэй уялдуулан үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны харилцан уялдааг сайжруулах;

- Цаашид шүүх байгууллагын бүтэц, тогтолцоонд өөрчлөлт, шинэчлэл хийхдээ харилцан уялдаатай ажилладаг байгууллагуудаас санал авч, тухайн шийдвэр хэрхэн нөлөөлөх талаар тэдний саналыг харгалзан үзэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, хамтарсан ажлын хэсэг байгуулах зэргээр арга хэмжээ авч байх;

- Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, хийгдэж буй шинэлэг үйл ажиллагааны талаар шүүгч, шүүхийн захиргааны ажилтан болон тахарын албаны албан хаагчид мэдээлэл муутай байгааг анхаарч тэдэнд шүүхийн шинэтгэлийн агуулга, ач холбогдлыг таниулах, сургалт, хэлэлцүүлэг тогтмол явуулах; улмаар шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл явцад шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнуудын саналыг тусгаж ажиллах;

3. Шүүхийн төсвийг бодит хэрэгцээнд тулгуурлан тооцож, шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах боломжоор хангах;

- Шүүхийн захиргааны зардлыг бодитоор тооцох, зохих судалгаа хийдэг байх;

- Шүүхийн олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа сумдад хүрч ажиллах боломж бололцоогоор хангах шаардлагатай байна.

1. Багануур, Налайх дүүрэг, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймгийн Зуунмод сум дахь анхан шатны 5 өөр шүүхээр үйлчлүүлэх болсон.

2. УХЦ-ийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Шүүх байгуулах тухай хуулийн 1,2 дугаар зүйлийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 1 дүгээр тогтоолын дагуу 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр “Шүүх байгуулах тухай хууль” дахин шинэчлэгдэн батлагдсан.